

**ПАЛЕОНТОЛОГИЙН СУДАЛГАА  
ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

**Баримтын төрөл:** Ажлын даалгавар

**Баримтын нэр:** Палеонтологийн судалгаа хийх

**Зорилго:**

Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль эрхзүйн хүрээнд палеонтологийн судалгааг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын эзэмшлийн талбайнуудад хийж, эртний амьтан, ургамлын (палеонтологийн) хайгуул судалгаа явуулж, тайлан дүгнэлтийг холбогдох байгууллагуудад албан ёсоор шилжүүлэх, бүртгэх, судлан тодорхойлоход оршино.

**Судалгаа хийгдэх газрын байршил:**

Байршил-1: MV-000174 тоот Бор-Өндөр орд

Байршил-2: MV-016657 тоот Баргилт орд

**Хийгдэх ажил, тавигдах шаардлага:**

1.	Хийгдэх ажлууд:	<p>Судалгааны ажлыг Монгол улсын нутаг дэвсгэрт палеонтологийн судалгааг хийх журмын дагуу салбарын шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйгээр гүйцэтгэнэ.</p> <ul style="list-style-type: none"><li>❖ Судалгааны явцад илэрсэн байгалийн олдворыг бүртгэн тэмдэглэх, түүнийг баримтжуулж, эрдэм шинжилгээний хайгуул судалгааны үр дүн гарсан даруйд захиалагчид хүргүүлэх;</li><li>❖ Захиалагч болон орон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэдэд хайгуул судалгаатай холбогдолтой мэдээллээр хангах, судалгааны үр дүнг танилцуулах, судалгааны явцад илэрч олдсон олдвор, эд зүйлсийг аюулгүй орчинд хадгалах, шаардлагатай бол авран хамгаалах суурин судалгааг хийх</li><li>❖ Хайгуул судалгааны явцад илэрсэн байгалийн дурсгалт зүйлсийн жагсаалтыг гаргах, палеонтологийн үлдвэр, үлдвэр агуулагч хурдсын судалгааг гүйцэтгэх;</li><li>❖ Палеонтологийн үлдвэрт нөлөөлөх нөлөөллийг судлах, багасгах арга хэмжээний дүгнэлт гаргаж</li></ul>
----	-----------------	---

		<p>Судалгааны ажлын тайланг гаргахдаа /Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 01-р сарын 04-ний өдрийн А/141 тоотын хавсралтын 8 дахь хэсэгт заасны дагуу гаргана./</p> <ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны ажлын тайлан нь орчин цагийн монгол хэлний найруулга зүйд нийцсэн техникийн алдаагүй монгол хэлээр, кирилл үсгээр бичигдсэн байна;</li> <li>• Судалгааны ажлын явц, үр дүнг бүрэн илэрхийлсэн бичвэр, гар зураг гэрэл зурагтай байх;</li> <li>• Судалгааны ажлын үр дүнгийн талаарх шинжлэх ухааны дүгнэлттэй байх;</li> <li>• Гадаад хэл дээрх холбогдох баримтын монгол орчуулгыг шаардлагатай бол хавсаргасан байх;</li> <li>• Судалгаа хийсэн олдвор эд зүйлсийг хэрхэн хадгалж хамгаалах талаар судалгааны санал оруулж өгөх</li> <li>• Тайланд хээрийн судалгааны явцад олж илрүүлсэн олдворийн хэмжээ, жин, төрх байдлыг илэрхийлсэн жагсаалтыг шаардлагатай бол хавсаргах</li> <li>• Хээрийн судалгааны явцад илрүүлсэн олдворын солбилцол бүхий жагсаалтыг хавсаргах;</li> <li>• Тайлан бичсэн эрдэмтэн, судлаачдаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна;</li> </ul>
2.	Судалгаа төлөвлөгөөний ажлын гүйцэтгэл, ҮР ДҮН	<p>Хэнтий аймгийн Дархан, Бор-Өндөр сумдын нутаг дэвсгэрт Монгол улсын хууль, холбогдох журмын дагуу палеонтологийн судалгааг “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын эзэмшлийн MV-000174 тоот Бор-Өндөр орд болон MV-016657 тоот Баргилт орд гэх 2 судалгааны талбайд хийж, хайгуул судалгааны ажлын тайланг шаардлагатай бол холбогдох мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулан, судалгаа хийсэн газар, ажлын гүйцэтгэлийн тайланг захиалагчид 2 хувь хэвлэмэл үйлдэж, цахим (PDF болон .docx) хэлбэрээр хүлээлгэж өгнө.</p>